

**БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО**

**МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН ДҮРЭМ**

**МЯНДАС ПОЛИМЕР АРМАТУРТАЙ  
БЕТОН, ТӨМӨР БЕТОН БҮТЭЭЦ**

**БД 52-110-20**

*Албан ёсны хэвлэл*

**МОНГОЛ УЛСЫН  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ  
УЛААНБААТАР ХОТ 2020 он**

БАРИЛГЫН НОРМАТИВ БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО  
МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН ДҮРЭМ

**МЯНДАС ПОЛИМЕР АРМАТУРТАЙ  
БЕТОН, ТӨМӨР БЕТОН БҮТЭЭЦ**

**БД 52-110-20**

Албан ёсны хэвлэл

МОНГОЛ УЛСЫН  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

Улаанбаатар хот 2020 он

Монгол Улсын Барилга, хот байгуулалтын Сайдын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тушаалаар батлав.

Боловсруулсан:

Я. ДҮЙНХЭРЖАВ	/Монгол Улсын зөвлөх инженер, Доктор (Ph.D)/
Б. ЛХАГВАСҮРЭН	/Монгол Улсын зөвлөх инженер/
Д. НАМСРАЙ	/Монгол Улсын зөвлөх инженер/
Г. ТУЛГА	/Монгол Улсын зөвлөх инженер/

Хянан тохиолдуулсан:

Н.ДАШ	/Монгол Улсын зөвлөх инженер/
Н.ЭРДЭНЭСҮРЭН	/Монгол Улсын зөвлөх инженер/

---

Энэхүү нормативын баримт бичгийг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүрэн болон хэсэгчлэн хувилах, олшруулах, тараахыг хориглоно.

## **МЯНДАС ПОЛИМЕР АРМАТУРТАЙ БЕТОН, ТӨМӨР БЕТОН БҮТЭЭЦ** **CONCRETE AND REINFORCED CONCRETE STRUCTURE WITH COMPOSITE REBAR**

### **1. Ерөнхий зүйл**

Энэхүү барилгын дүрэм нь “Бетон ба төмөр бетон бүтээц. Ерөнхий журам” /БНБД 52-01-10/-ийн заавал биелүүлэх шаардлагуудыг хангахад чиглэгдсэн бөгөөд метал бус нийлэг арматуртай бүтээцийг тооцож төсөллөхөд баримтлах шаардлагуудыг тогтооно.

### **2. Хэрэглэх хүрээ**

2.1. Энэхүү барилгын дүрэм нь төрөл бүрийн зориулалттай барилга байгууламжийн мяндас-полимер арматур /FRP/-аар арматурчлах бүтээцэд хамаарна.

2.2. Мяндас-полимер арматур нь орчны идэмхий үйлчлэлд ашиглагдах бүтээцийг арматурчлахад илүү тохиромжтой.

Бүтээцийг арматурчлахад MNS GOST 31938:2015-ын шаардлагыг хангасан дараах төрлүүдийн мяндас-полимер арматурыг ашиглана. Үүнд:

- шилэн мяндас-полимер арматур(GFRP)
- хүрмэн мяндас-полимер арматур(BFRP)
- нүүрсэн мяндас-полимер арматур(CFRP)
- араид мяндас-полимер арматур(AFRP)
- нийлмэл мяндас-полимер арматур (Combined FRP)

Мяндас-полимер арматурын төрлийг сонгохдоо бүтээцийн ашиглалтын нөхцөл, ачааллын шинж байдал болон эдийн засгийн үр ашгийг харгалзана.

2.3. Мяндас-полимер арматурыг газар хөдлөлтийн үйлчлэлээр үүсэх гулзайлгах болон дагуу хүчний үйлчлэлд ажиллах рамын элементүүд, ханын хүрээлэх элементүүдийн дагуу арматурт хэрэглэхгүй.

2.4. Нэг огтлолд, нэг хүчлэлийг хүлээж авах зориулалтаар мяндас полимер арматурыг бусад өөр төрлийн арматуруудтай хамт хэрэглэхгүй.

### **3. Норматив ишлэл**

Энэ барилгын дүрэмд дараах норматив баримт бичгүүдийг иш татаж хэрэглэсэн.

- БНБД 20-01-11 “Барилгын бүтээц ба буурийн найдваршил. Ерөнхий шаардлага”;
- БНБД 20-02-11 “Барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах төлөвлөлт”
- БНБД 20-04-16 “Ачаалал ба үйлчлэл”;
- БНБД 52-01-10 “Бетон ба төмөр бетон бүтээц”;
- БД 52-105-10 “Бетон ба урьдчилан хүчитгээгүй арматуртай төмөр бетон бүтээц”;
- БД 52-108-16 “Урьдчилан хүчитгэсэн төмөр бетон бүтээц”;
- MNS 2228:2002 “ Угсармал бетон, төмөр бетон бүтээц, эдлэхүүн. Техникийн ерөнхий шаардлага”
- MNS GOST 31938:2015 “Бетон бүтээцийг арматурчлах мяндас-полимер (FRP) арматур. Техникийн ерөнхий шаардлага”

*Тайлбар: Энэхүү норм ба дүрмийг мөрдөх явцад ишлэл авсан баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт хийсэн буюу шинэчилсэн байвал тэдгээр нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн баримт бичгийг мөрдөнө.*

### **4. Нэр томьёо, тодорхойлолт**